



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** АРА-2022/88/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг Тариат сум 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: <a href="mailto:Baigalmaat@audit.gov.mn">Baigalmaat@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: <a href="mailto:Nerguibaatard@audit.gov.mn">Nerguibaatard@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Монголиан бизнес рейтинг-Аудит ХХК Утас: 70005329 Цахим хаяг:<a href="mailto:mbr.audit.llc@gmail.com">mbr.audit.llc@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



## АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ М.БОЛОР-ЭРДЭНЭ  
ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠔ № 77

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>173,492,992.97</b>	<b>162,601,116.46</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,631,322.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,631,322.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,631,322.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	171,861,670.97	162,601,116.46
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	86,401,214.49	89,028,814.17
35110	Тусгай зориулалттай материал	83,886,214.49	81,054,814.17
35130	Эм боох материал	2,515,000.00	7,974,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	83,835,456.48	71,572,302.29
35410	Бичиг хэргийн материал	4,048,002.10	4,039,417.29
35420	Аж ахуйн материал	45,299,794.38	35,454,560.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,620,600.00	-
35440	Түлш, шатах төслох материал	5,399,250.00	4,223,000.00
35450	Барилгын засварын материал	20,654,260.00	21,559,760.00
35460	Хүнсний материал	1,262,050.00	395,965.00
35470	Бусад хангамжийн материал	4,551,500.00	5,899,600.00
35600	Мал амьтад	1,625,000.00	2,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,853,588,235.63</b>	<b>1,886,268,726.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,853,588,235.63	1,886,268,726.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,735,790,235.63	1,767,510,726.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,685,053,437.60	1,777,866,037.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(143,988,051.12)	(215,982,076.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,800,000.00	10,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,800,000.00)	(10,800,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	195,262,505.71	209,077,138.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(147,415,580.40)	(130,830,153.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	169,336,908.21	139,588,560.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	(79,355,778.66)	(72,333,726.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,011,486.00	46,411,486.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,611,742.04)	(22,715,678.02)
39217	Ном	34,497,050.33	36,429,139.89
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	117,798,000.00	118,758,000.00
39301	Програм хангамж	-	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(240,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	118,098,000.00	118,098,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(300,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,027,081,228.60</b>	<b>2,048,869,843.39</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>275,100,459.00</b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	275,100,459.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	275,100,459.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	275,100,459.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	275,100,459.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>206,437,681.84</b>	<b>503,326,755.63</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	206,437,681.84	503,326,755.63
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(713,951,020.09)	(417,061,946.30)
51210	Өмнөх үеийн үр дүн	(713,951,020.09)	(713,951,020.09)
51220	Тайлант үеийн үр дүн	-	296,889,073.79

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	920,388,701.93	920,388,701.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>481,538,140.84</u></b>	<b><u>503,326,755.63</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>958,476,961.91</b>	<b>1,816,529,685.45</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,666,061.91</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,666,061.91	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,666,061.91	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,666,061.91	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>956,810,900.00</b>	<b>1,816,529,685.45</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	793,081,300.00	1,127,108,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	793,081,300.00	1,127,108,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	26,785,885.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	25,401,785.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,384,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	163,729,600.00	662,635,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,729,600.00	662,635,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>896,622,552.48</b>	<b>1,655,301,630.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>896,622,552.48</b>	<b>1,655,301,630.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	893,423,852.48	1,611,970,220.92
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	539,964,872.00	876,752,500.00
210101	Үндсэн цалин	371,535,672.00	629,631,678.00
210102	Нэмэгдэл	121,895,200.00	164,225,077.00
210104	Урамшуулал	46,534,000.00	82,895,745.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,712,844.00	118,004,422.00
210201	Тэтгэврийн даатгал	45,443,103.00	86,382,422.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,317,435.00	7,905,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,253,948.00	6,324,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,063,487.00	1,581,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,634,871.00	15,811,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	221,795,899.00	391,159,091.00
210301	Гэрэл, цахилгаан	3,136,473.00	4,265,589.00
210302	Түлш, халаалт	218,659,426.00	374,232,502.00
210303	Цэвэр, бохир ус	-	12,661,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,187,700.00	29,475,835.34
210401	Бичиг хэрэг	1,298,500.00	5,987,344.90
210402	Тээвэр, шатахуун	1,624,550.00	-

Архангай аймгийн Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	697,200.00
210404	Ном, хэвлэл	280,000.00	1,562,060.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,334,650.00	21,123,004.38
210408	Бараа материал акталсны зардал	-	106,226.06
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,458,950.00</b>	<b>58,143,075.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	15,841,900.00
210502	Хоол, хүнс	9,458,950.00	42,301,175.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>3,715,100.00</b>
210604	Урсгал засвар	-	3,715,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>850,000.00</b>	<b>6,371,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	6,371,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>49,453,587.48</b>	<b>128,348,597.58</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	297,000.00	14,011,417.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,156,587.48	114,337,179.94
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,198,700.00</b>	<b>43,331,410.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,198,700.00</b>	<b>37,458,900.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,198,700.00	35,658,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,800,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>5,872,510.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,872,510.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>61,854,409.43</u></b>	<b><u>161,228,054.53</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>4,924,036.42</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,299,036.42
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,625,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(4,924,036.42)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>61,854,409.43</u></b>	<b><u>156,304,018.11</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>956,810,900.00</u></b>	<b><u>1,816,529,685.45</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>956,810,900.00</b>	<b>1,816,529,685.45</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	793,081,300.00	1,127,108,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	793,081,300.00	1,127,108,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	26,785,885.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	25,401,785.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,384,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	163,729,600.00	662,635,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,729,600.00	662,635,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>887,761,438.00</u></b>	<b><u>1,795,059,885.45</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>887,761,438.00</b>	<b>1,795,059,885.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>876,264,218.00</b>	<b>1,752,247,975.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	607,470,388.00	876,752,500.00
210101	Үндсэн цалин	422,750,988.00	629,631,678.00
210102	Нэмэгдэл	138,185,400.00	164,225,077.00
210104	Урамшуулал	46,534,000.00	82,895,745.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	75,057,283.00	116,373,100.00
210201	Тэтгэврийн даатгал	51,117,322.00	84,751,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,984,990.00	7,905,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,787,992.00	6,324,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,196,998.00	1,581,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,969,981.00	15,811,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	162,163,602.00	660,635,400.00
210301	Гэрэл, цахилгаан	3,136,473.00	4,265,589.00
210302	Түлш, халаалт	159,027,129.00	643,708,811.00
210303	Цэвэр, бохир ус	-	12,661,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,412,750.00	13,186,585.45
210401	Бичиг хэрэг	750,900.00	2,045,385.45
210402	Тээвэр, шатахуун	1,624,550.00	4,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	650,000.00	697,200.00
210404	Ном, хэвлэл	280,000.00	1,820,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	447,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,107,300.00	4,175,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	25,087,995.00	64,289,790.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	361,400.00	20,363,100.00
210502	Хоол, хүнс	24,726,595.00	41,704,590.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,222,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	2,000,000.00
210604	Урсгал засвар	-	2,000,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	965,000.00	16,295,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	365,000.00	16,295,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,107,200.00	2,715,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,107,200.00	2,715,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,497,220.00	42,811,910.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,497,220.00	36,939,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,497,220.00	35,389,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,550,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,872,510.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,872,510.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	69,049,462.00	21,469,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,500,000.00	21,469,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,500,000.00	21,469,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,500,000.00	21,469,800.00
223001	Бусад хөрөнгө	6,500,000.00	21,469,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,500,000.00)	(21,469,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	62,549,462.00	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,545,543,087.76	920,388,701.93	(680,433,972.76)	1,785,497,816.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,545,543,087.76</b>	<b>920,388,701.93</b>	<b>(680,433,972.76)</b>	<b>1,785,497,816.93</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(47,277,650.57)	(47,277,650.57)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,545,543,087.76</b>	<b>920,388,701.93</b>	<b>(727,711,623.33)</b>	<b>1,738,220,166.36</b>
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,545,543,087.76</b>	<b>920,388,701.93</b>	<b>(727,711,623.33)</b>	<b>1,738,220,166.36</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-

<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,545,543,087.76</b>	<b>920,388,701.93</b>	<b>(727,711,623.33)</b>	1,738,220,166.36
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	296,889,073.79	296,889,073.79
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,545,543,087.76</b>	<b>920,388,701.93</b>	<b>(430,822,549.54)</b>	2,035,109,240.15

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,789,743,800.00	1,783,871,290.00	5,872,510.00	99.67
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,789,743,800.00	1,783,871,290.00	5,872,510.00	99.67
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,749,906,400.00	1,746,931,890.00	2,974,510.00	99.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	876,752,500.00	876,752,500.00	-	100.00
210101	Үндсэн цалин	640,089,600.00	629,631,678.00	10,457,922.00	98.37
210102	Нэмэгдэл	162,231,000.00	164,225,077.00	(1,994,077.00)	101.23
210104	Урамшуулал	74,431,900.00	82,895,745.00	(8,463,845.00)	111.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	116,373,100.00	116,373,100.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	84,751,100.00	84,751,100.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,905,500.00	7,905,500.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,324,400.00	6,324,400.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,581,100.00	1,581,100.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,811,000.00	15,811,000.00	-	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	660,635,400.00	660,635,400.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	11,453,400.00	4,265,589.00	7,187,811.00	37.24
210302	Түлш, халаалт	642,582,000.00	643,708,811.00	(1,126,811.00)	100.18
210303	Цэвэр, бохир ус	6,600,000.00	12,661,000.00	(6,061,000.00)	191.83
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,373,500.00	11,373,500.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	1,616,400.00	1,616,400.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	697,200.00	697,200.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	436,700.00	436,700.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	447,900.00	447,900.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,175,300.00	4,175,300.00	-	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	67,264,300.00	64,289,790.00	2,974,510.00	95.58

Архангай аймгийн Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,363,100.00	20,363,100.00	-	100.00
210502	Хоол, хүнс	44,679,100.00	41,704,590.00	2,974,510.00	93.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,222,100.00	2,222,100.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,892,600.00	6,892,600.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,892,600.00	6,892,600.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,615,000.00	8,615,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,615,000.00	8,615,000.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	39,837,400.00	36,939,400.00	2,898,000.00	92.73
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	39,837,400.00	36,939,400.00	2,898,000.00	92.73
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,287,400.00	35,389,400.00	2,898,000.00	92.43
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,550,000.00	1,550,000.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,789,743,800.00	1,783,871,290.00	5,872,510.00	99.67
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,127,108,400.00	1,121,235,890.00	5,872,510.00	99.48
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,127,108,400.00	1,121,235,890.00	5,872,510.00	99.48
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	662,635,400.00	662,635,400.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	662,635,400.00	662,635,400.00	-	100.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	74.00	76.00	(2.00)	102.70
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	50.00	51.00	(1.00)	102.00
620003	Үйлчлэх ажилтан	23.00	24.00	(1.00)	104.35
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	767.00	840.00	(73.00)	109.52
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	767.00	840.00	(73.00)	109.52
630001	Төрийн өмчит ЕБС	767.00	840.00	(73.00)	109.52
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>71.00</b>	<b>75.00</b>	(4.00)	105.63
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	46.00	49.00	(3.00)	106.52
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	25.00	26.00	(1.00)	104.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,785,885.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32,785,885.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	32,785,885.45
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,813,085.45
210401	Бичиг хэрэг	428,985.45
210404	Ном, хэвлэл	1,384,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	24,972,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,972,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>(6,000,000.00)</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	(6,000,000.00)
223001	Бусад хөрөнгө	(6,000,000.00)
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	26,785,885.45
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	26,785,885.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,401,785.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,384,100.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Солонготуяа, аудитор А.Жамъян нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Н.Алтанзул, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Хүүхэд бүрд чанартай боловсрол олгож, авьасыг нээн хөгжүүлж, эрүүл ахуйн зөв дадал, хүмүүжлийн эерэг хандлагыг төлөвшүүлэхэд оршино" гэж тодорхойлжээ.

Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн боловсрол олгодог байх;
- Ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлж хууль дүрмийг хэрэгжүүлэх;
- Боловсролын чанарыг ямагт сайжруулан ажиллах;
- Үйл ажиллагааны менежментийн хамгийн оновчтой хувилбарыг цогцлоон хөгжүүлэх;
- Сургалтыг дэмжих үйл ажиллагаа;
- Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Харин дотоод хяналтыг зөвхөн сургалтын үйл

ажиллагаа, анги танхимын эрүүл ахуй, хүүхдийн эрүүл мэнд, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагын хүрээнд хийж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,620.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 16.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21.9 сая төгрөгөөр буюу 1.08 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	171.8	162.6	(9.2)
Биет хөрөнгө	1,735.8	1,767.5	31.7
Биет бус хөрөнгө	117.8	118.8	1.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,027.0</b>	<b>2,048.9</b>	<b>21.9</b>
Хуримтлагдсан үр дүн	(713.9)	(417.0)	296.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,027.0</b>	<b>2,048.9</b>	<b>21.9</b>

3.5.1. Бараа материалын дансны үлдэгдэл 162.6 сая төгрөг болж 9.2 сая төгрөгөөр буурсан байна. Тусгай зориулалттай материал 2.8 сая төгрөгөөр, хангамжийн материал 12.3 сая төгрөгөөр, аж ахуйн материал 9.8 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

3.5.2. Биет хөрөнгө дансны үлдэгдэл 31.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 92.8 сая төгрөгийн барилга байгууламж, 13.8 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Архангай аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 101 дугаар шийдвэрээр элэгдлээрээ өртгөө нөхсөн 61.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж тайлагнасан байна.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 1.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд программ хангамжийн 1.0 сая төгрөгийн өсөлтөөс шалтгаалжээ.

3.5.3. Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл (417.0) сая төгрөг болж 296.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд дээд шатны байгууллагаас 128.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 883.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 758.7 сая төгрөгөөр буюу 84.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн цалин, бусад бараа үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний зардал, болон байр ашиглалттай холбоотой зардал байна.

### Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая.төг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	956.7	1,789.7	833.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	1.6	140.5	138.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	26.7	26.7
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	128.8	128.8
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	11.7	11.7
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>958.4</b>	<b>1,957.1</b>	<b>998.7</b>
Цалин, шимтгэлийн зардал	606.6	994.7	388.1
Бусад бараа үйлчилгээний зардал	236.5	480.2	243.7
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.8	6.3	5.5
Бараа үйлчилгээний бусад зардал	49.4	128.3	78.9
Урсгал шилжүүлэг	3.2	43.3	40.1
Хөрөнгө шилжүүлсэн	-	-	-
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>896.6</b>	<b>1,655.3</b>	<b>758.7</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>61.8</b>	<b>301.8</b>	<b>240.0</b>

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 833.0 сая төгрөг буюу 53.4 хувиар өссөн нь байна. Тайлант онд үйл ажиллагааны орлого 138.9 сая төгрөгөөр өссөн нь нийт үр дүн өсөхөд нөлөөлсөн байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,060.2 сая, орон нутгийн төсвөөс 339.0 сая, нийт 1,399.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан байна.

Тайлант хугацаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн сумын төсөвт 4 удаа өөрчлөлт оруулж, төсвийг 390.4 сая төгрөгөөр өсгөж, 1,789.7 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: Цалин болон нэмэгдэл урамшлын зардлыг 86.1 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 10.0 сая төгрөг, нормативт зардлыг 35.4 сая төгрөгөөр байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,789.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 1,127.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 662.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,121.2 сая, орон нутгийн төсвөөс 662.6 сая, нийт 1,789.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,783.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,783.8 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь нормативт зардлыг 2.9 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох, шагнал урамжуулал зардлыг 2.9 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Түрээсийн сурах бичгийн төлбөр 1.4 сая, БШУС-ын 2021 оны А/280 дугаар тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн 8,000.0 сая, БШУС-ын 2021 оны А/279 дугаар тушаалаар ариутгалд зориулан Засгийн газрын нөөц сангаас 0.5 сая төгрөг, Аймгийн ЗДТ-газраас Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн санхүүжилтэнд 7.5 сая, Тогтвортой хөгжлийн боловсрол төслөөс 6.0 сая, Аймгийн БОАЖ-гаkraас Эзо клубийн төслийн санхүүжилт 3.0 сая төгрөг нийт 26.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 26.8 сая төгрөг буюу 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй.

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 99.6 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 885.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,783.9 сая төгрөгийг зарцуулж, 99.6 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:
  - Албан конторын тавилга, шагнал, албан томиллолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2. Цар тахалтай хандив тусламжтай холбоотой: Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив, тусламж хүлээн аваагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд тайлант онд 149 мэдээлэл байршуулхаас 121 мэдээлэл хугацаанд нь оруулж, 11 мэдээлэл огт оруулаагүй, 17 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.4, 6.5.6 дахь заалтуудтай нийцээгүй ба өмнөх оны аудитаар өгсөн “Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд тайлагнах” гэсэн зөвлөмжийг биелүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны мэдээллийг бүрэн оруулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул МУЕА-ын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.1.2.10-д заасны дагуу албан шаардлага хүргүүлэв.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг тулган шалгахад батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, байр ашиглалттай холбоотой зардлыг 20-оос доошгүй хувийг хэмнэж ажиллаагүй, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулж ажиллаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөрчил арилгах 1 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлсэн байна. Өмнөх оны зөвлөмж, албан шаардлагыг тайлант онд биелүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлэв.

Залруулагдаагүй 3 алдаа, зөрчлийн дүн 8.6 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 16.2 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 4.1 Албан шаардлага

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 0.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай 2 төрлийн 22 ширхэг хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн тодорхойлолт 13 дугаар зүйл Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө: а.Бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэд, бусдад түрээслэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшиж байгаа; б.Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын дансанд бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх.

#### Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтын системд 5.8 сая төгрөгийн төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д "Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудтай нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Цахим төлбөрийн баримтын гүйцэтгэлд хяналт тавьж, и-баримтыг шаардан авч, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар зөрчлийг давтан гаргахгүй байх

#### Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд ном хэвлэл /210404/ зардлын данснаас 0.07 сая төгрөгийн маягтын үнэ, Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал /210405/ зардлын

данснаас 0.5 сая төгрөгийн шатахууны үнэ, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж /210801/ зардлын данснаас 0.2 сая төгрөгийн сургуулийн торгуулийн үнэ, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ зардлын данснаас 0.2 сая төгрөгийн багш нарын шагнал, 0.4 сая төгрөгийн ажлын хөлс, 0.2 сая төгрөгийн бичгийн цаасны үнэ, 0.5 сая төгрөгийн хорны зардлыг гаргасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Тариат сумын ЕБС	4	8.6					1		3	8.6
Дүн		4	8.6					1		3	8.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Тариат сумын ЕБС	2	-					2	-		
Дүн		2	-					2	-		
<b>Нийт дүн</b>		<b>6</b>	<b>8.6</b>					<b>3</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>8.6</b>



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 168/2022-13

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Тариат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар тайлант онд "Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй, төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх арга хэмжээ авч биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тариат сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Болор-Эрдэнэ, нягтлан бодогч Г.Гантамир нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ  
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ" ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ





АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 169/20230&13

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Тариат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих 149 мэдээллээс 17 мэдээллийг хугацаа хоцроосон, 11 мэдээллийг огт байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал", 2021 оны А/108 тушаалын хавсралтаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 3.1.1 "Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй бол зөрчил арилгах албан шаардлага өгөх" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж мэдээллийг нөхөн байршуулан биелэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тариат сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Болор-Эрдэнэ, нягтлан бодогч Г.Гантамир нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ

"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ

